

“ТОГТООЛД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2026 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр

Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тухай хуулийн дагуу Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь Эрүүл мэндийн даатгалын сангийн батлагдсан төсөвт багтаан, иргэн, даатгуулагчдын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, эмнэлзүйн хувьд үр дүнтэй, эдийн засгийн хувьд үр ашигтай тусламж, үйлчилгээг худалдан авах замаар иргэн даатгуулагчдын хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээ авах эрхийг хангах, улмаар эрүүл мэндээс үүдэлтэй санхүүгийн эрсдлээс хамгаалах бодлогыг баримталж ажилладаг.

Төр төлбөрийг нь хариуцах эмийн зардалыг тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар эрүүл мэндийн байгууллагын эм худалдан авсан ширхэг бүрийн үнээр тооцон Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж байна. Төр төлбөрийг нь хариуцах эмийн санхүүжилт жил бүр нэмэгдэж байгаа хэдий ч эрүүл мэндийн байгууллагын эмийн нөөц бүрэн хангагдаагүй хэвээр байна.

Төрөл	2023 оны гүйцэтгэл	2024 ны гүйцэтгэл	2025 оны гүйцэтгэл	Өөрчлөлтийн хувь (2024-2025)
Төр хариуцах эм	11,348.30	35,275.90	60,294.60	70.9%

Иймээс уг тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хүлээгдэлийг бууруулах, төсвийг үр ашигтай зарцуулахын тулд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2026 оны 07 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар баталсан “Төрөөс төлбөрийг нь хариуцах эмийн зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх журам”-ын “Эрүүл мэндийн байгууллагад олгох төлбөрийг нь төр хариуцах эмийн нэхэмжлэл, нэхэмжлэлийн хяналт, санхүүжилт” гэсэн хэсэгт эмийн үнэ тогтоох зарчмыг тусгасан.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2026 оны “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам батлах тухай” 07 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх төлбөрийн арга”-ын 3 дугаар зүйлийн 3.1.2 дах хэсэгт заасан “Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн сүлжээг шинэчилсэн,” тохиолдолд суурь тарифыг өөрчлөхөөр заасан.

Монгол Улсын Засгийн Газрын шийдвэрээр эрүүл мэндийн салбарын албан хаагчдын цалинг 2026 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 20 хувиар нэмэгдүүлэхээр Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулахаар хэлэлцэж байгаа тул Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2026 оны 07 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар

баталсан суурь тарифын хэмжээнд өөрчлөлт оруулахаар холбогдох тооцооллыг хийж, төлбөрийн хэмжээг нэмэгдүүлэхээр тусгасан.

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГААС ЗАРДЛЫН
ТӨЛБӨРИЙГ НЬ ХАРИУЦАХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
СУУРЬ ТАРИФ, ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРЛӨӨР**

№	Тусламж, үйлчилгээний нэр төрөл	Суурь тариф /төгрөг/	Шинэ суурь тариф /төгрөг/	Өсөлтийн хувь
1	Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	1,021,550	1,072,628	5%
2	Амбулаторийн үзлэг, хяналт, эмчилгээ, оношилгоо, шинжилгээ	36,055	37,858	5%
3	Яаралтай тусламж, үйлчилгээ	102,155	107,263	5%
4	Түргэн тусламж, үйлчилгээ	54,082	56,786	5%
5	Телемедицин	58,320	61,236	5%
6	Өдрөөр үзүүлэх тусламж, үйлчилгээ	269,568	283,046	5%
7	Сэргээн засах тусламж, үйлчилгээ	786,240	825,552	5%
8	Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ	988,416	1,037,837	5%
9	Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ	505,440	530,712	5%
10	Сувиллаас үзүүлэх тусламж, үйлчилгээ	280,800	294,840	5%

Иймд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9.8-д заасны дагуу “Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоолын төсөл боловсруулж, Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-д заасны дагуу санал авахаар байршуулж байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР